



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 0/369

Улаанбаатар хот

**Үнэлгээний хороо байгуулах
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.1, 47.4 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/990 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр 2019 онд санхүүжих Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдаас Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид эрх шилжүүлсэн Баянгол дүүргийн 3 дугаар хороо, Нарны хороололд “960 хүүхдийн өрөнхий боловсролын сургууль, 280 хүүхдийн цэцэрлэгийн барилга, тоног төхөөрөмж, гадна инженерийн шугам сүлжээ, тохижилтын ажлын хамт худалдан авах” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж ажиллахыг Үнэлгээний хороо /Д.Рэнцэнбямба/-нд үүрэг болгосугай.


3. Худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга Д.Итгэлд үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115050001119

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 10 дугаар сарын 18 өдрийн 1369 дугаар тушаалын хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:	Д.Рэнцэнбямба	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын орлогч даргын үүрэг гүйцэтгэгч
Гишүүд:	Ж.Энхтөр	Нийслэлийн Боловсролын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн хэлтсийн дарга
	С.Болдбаатар	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын Худалдан авах ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Б.Пүрэвсүрэн	Баянгол дүүргийн 6 дугаар хороо, 47-2-5 тоот /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга:	Д.Итгэл	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн дарга